

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### **1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх, эдийн засагт тулгуурласан хөгжлийн гарц, боломжийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсон шинэ санаа, санаачлагыг нээн гаргаж, цаашид хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон Сэлэнгэ аймгийн харъяат дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцаж буй оюутан, залуучуудын дунд зохион байгуулдаг “Сэлэнгэ аймгийн хөгжлийн гарц” сэдэвт илтгэлийн уралдааныг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зарлалаа.

Монгол Улсын Төрийн албаны Зөвлөл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, аймгийн Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн тогтвортой хөгжлийн институт хамтран 2015 оны 04 сарын 02-03-ны өдрүүдэд “Орон нутгийн хөгжил ба төрийн захиргааны шинэчлэл” сэдэвт Сэлэнгэ, Баянхонгор, Увс, Өвөрхангай аймгуудын төрийн албан хаагчдын төлөөлөл оролцсон уулзалт зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Т.Хадхүү “Төрийн албаны шинэчлэл”, Сэлэнгэ аймгийн Засаг дарга “Сэлэнгэ аймгийн хөгжил-Төрийн захиргааны шинэчлэл”, Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч О.Батжаргал “Өвөрхангай аймгийн хөгжил-Төрийн захиргааны шинэчлэл”, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Г.Болор-Эрдэнэ “Увс аймгийн хөгжил-Төрийн захиргааны шинэчлэл”, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга С.Баярмаа “Баянхонгор аймгийн хөгжил-Төрийн захиргааны шинэчлэл” сэдвүүдээр илтгэл тавьж, илтгэл, мэдээлэлтэй холбогдуулан төрийн албан хаагчид хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээгээ тодотгон, харилцан туршлага солилцлоо.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат 2015 оны 04 сарын 03-ны өдөр Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай танилцаж, албан хаагчидтай уулзалт зохион байгуулан тэдний санал хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаа явуулахад нэн яаралтай, тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцлээ. Тус газрын албан хаагчдаас гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахад, үерийн даланг сэргээн засварлахад, түймрийн пост ажиллуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, гол усанд золгүй байдлаар эрсдэх байдал гардаг тул урьдчилан сэргийлэх эргүүл хамгаалалтын ажилд эрх зүйн туслалаа хэрэгтэй байгаа, олон сараар гэр орноо мартан явдаг алба хаагчдын ар гэрийн нийгмийн асуудал хүндрэлтэй байдаг, ашиглаж байгаа техник хуучирч муудсан, усны болон эрсдлийн үеийн хувцас өмсгөл дутагдалтай байгаа талаар хэлэлцлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн тариаланчидтай хамтран 2015 оны 04-р сарын 14-ний өдөр нэгдсэн зөвлөгөөн зохион байгууллаа. Өндөр ач холбогдол бүхий тус зөвлөгөөнд ХХААЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Н.Ариунболд, яамны газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Болорчулуун, Дархан-Уул аймгийн ХХААГ-ын дарга Ц.Энхжаргал, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн тариаланчидын төлөөлөл оролцлоо. Зөвлөгөөнөөр, “Хаврын тариалалтын бэлтгэл, цаашид анхаарах асуудал”, “Газар тариалангийн салбарын 2015 оны зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Дулааны улирлын цаг уурын ерөнхий төлөв”, “Цаг агаарт зориудаар нөлөөлсөн ажлын үр дүн, “Хаврын тариалалтын технологийн



**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

3-р сарын 30-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	3 428 543.0	3 605 088.9	105.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2 908 584.2	2 599 518.6	89.4
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	4 508 747.5	3 279 764.1	72.7
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	1 916 106.7	1 236 858.6	64.6
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	413 684.1	327 673.8	79.2
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	56 800.0	630.5	1.1
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	110 400.0	-	0.0
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	560 500.0	763 446.7	136.2
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1 636 466.0	1 636 466.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11 214 319.1	11 214 319.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	5 823 881.6	5 823 881.6	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2 898 298.9	2 898 298.9	100.0
	- Эрүүл мэнд, спортын байгууллага	1 511 019.9	1 511 019.9	100.0
	- Соёлын байгууллагуудын	817 215.5	817 215.5	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	75 295.9	75 295.9	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	88 607.3	88 607.3	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11 214 319.1	11 214 319.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	5 823 881.6	5 823 881.6	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2 898 298.9	2 898 298.9	100.0
	- Эрүүл мэнд	1 305 563.1	1 305 563.1	100.0
	- Спортын байгууллага	205 456.8	205 456.8	100.0
	- Соёлын байгууллагуудын	817 215.5	817 215.5	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	75 295.9	75 295.9	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	88 607.3	88 607.3	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1 435 442.4	1 435 442.4	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	306 824.3	327 073.8	106.6
9	Аймгийн нийт нөөц хөрөнгө гүйцэтгэл	268 301.0	165 261.1	61.6
10	Үүнээс Аймгийн Засаг даргын нөөц	213 300.0	116 776.2	54.7

2015 оны төсвийн гүйцэтгэлийн 3 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 97.9 хувь, улсаасавах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 36.1 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэнбайна. Төсвийн зарлагын

гүйцэтгэл 83.8 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдынсанхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 65.4 хувийнгүйцэтгэлтэй гарсан байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2015	2015	<u>2015-III</u>
		II- сар	III- сар	2015-II
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1000	1000	100
	Нарийн боов /кг/	1800	1800	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
<b>2</b>	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	6500	7500	115.4
	Үхрийн мах /кг/	7500	8500	113.3
	Адууны мах /кг/	6000	6500	108.3
	Ямааны мах /кг/	6000	6800	113.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	5000	5000	100.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1400	1200	86
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1800	1600	88.9
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	300	300	100
<b>4</b>	<b>Бүх төрлийн өөх тос</b>			
	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	3500	3500	100
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1500	1500	100
	Лууван /кг/	1500	1200	80
	Манжин /кг/	1500	1500	100
	Байцаа /кг/	1500	1500	100
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
<b>2</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1590	1590	100
	Бензин А - 92	1690	1700	100
	Дизелийн түлш	1830	1830	100

**Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

**1. Архивын талаар:**

Байгууллагын архивын цахим сан бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам, боловсруулан аймгийн Засаг даргын 2015 оны А/160 тоот захирамжаар баталгаажуулан, нийт сумд агентлагуудад хүргүүлээ.

Хөмрөг үүсгэгч байгууллагуудын дунд “Тэргүүний архив” шалгаруулах болзолт уралдаан зарлаж, байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч нарт зааварчилгаа өгч, мэдээлэл хүргүүлээ.

Татан буугдсан байгууллагуудын цалингийн цэсийг сан хөмрөгт татаж авах зорилгоор татан буугдсан нийт 43 байгууллагын судалгааг гарган, мэдээллийн бааз үүсгэлээ.

Сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтанд хэсэгчилсэн тооллого хийх ажлын хүрээнд аймгийн Ойн аж ахуйн 1969-1990 оны 190 хадгаламжийн нэгжид тооллого хийн, нийтийн аж ахуйн үйлчилгээний 1964-1975 оны баримтуудад иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийлээ.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Цагаантолгой сангийн аж ахуй, Хүдэрийн Тэжээлийн аж ахуйн нийт 35 хадгаламжийн нэгжийн 5582 хуудсыг AMS программд шивэлт хийн, холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мастер хувиас ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд нийт 31 хадгаламжийн нэгжийн 5582 хуудас баримтанд ашиглалтын хувь үүсгэлээ.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу давхардсан тоогоор нийт 40 гаруй иргэнд үйлчилж, архивын хуулбар 146, магадлагаа 6, тодорхойлолт 11, цалингийн тодорхойлолт Згарган үйлчиллээ.

### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Боловсролын чиглэлээр:**

Улсын төрөлжсөн олимпиадад 2015 оны 04 дүгээр сарын 23-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 13 төрлийн хичээлээр 28 сурагч, 21 багш оролцон, Түүх, нийгмийн ухааны хичээлээр Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн 12-р ангийн сурагч С.Соёлмаа мөнгөн медаль, биологийн хичээлээр Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн сурагч Б.Алтанзул алтан медаль, Сэтгэх чадвараар Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш Ц.Тунгалаг хүрэл медаль, газарзүйн хичээлээр Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Ж.Туул IV байр, Англи хэлний хичээлээр Мандал сумын Билиг ДБ сургуулийн Багш Г.Ганжаргал тусгай байр эзэлсэн амжилтыг тус тус үзүүлээ.

Аймгийн Боловсрол соёлын газар, Б.Ринченгийн нэрэмжит Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуультай хамтран 2015 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд Монгол бичгийн улсын олимпиадыг аймагтаа зохион байгууллаа. Олимпиадад нийт 21 аймаг, 4 дүүргийн монгол хэл, бичгийн 26 багш, 12-р ангийн 23 сурагч оролцож Ховд аймгийн багш, Сүхбаатар аймгийн сурагч тэргүүн байрыг эзэллээ.

“Бидний оролцоо сарын аян”-ы хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, сурах бэрхшээл, зан төлвийн өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллах арга зүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тав тухтай орчинд сурч хөгжихөд багшийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Боловсрол, соёлын газраас 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Алтанбулаг, Зүүнбүрэн, Сүхбаатар, Шаамар, Дулаанхан зэрэг сумын сургуулийн өмнөх боловсролын 10 багш, бага ангийн 10 багш, дунд ангийн анги удирдсан 10 багш, насан туршийн боловсролын 5 багш, эцэг эхийн төлөөлөл 10, нийт 45 хүн оролцлоо.

2015-2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид элсэгчдийн Монгол хэл бичгийн дахин шалгалтыг 2015 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Боловсролын үнэлгээний төв, аймгийн Боловсрол соёлын газар хамтран зохион байгуулж 104 хүүхэд шалгалт өглөө.

2015-2016 оны хичээлийн жилээс “Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр” түүнийг дагалдах “Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас”-ыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэгийн бүх багш нарын сургалт 2015 оны 04 сарын 12-15-ны хооронд зохион байгуулагдаж 39 цэцэрлэгийн 288 багш, арга зүйч, эрхлэгч нар хамрагдлаа.

2015 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийг Боловсрол соёлын газар, Сайхан сумын Хөтөл ерөнхий боловсролын сургуультай хамтран “Аймгийн бага ангийн багш нарын анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 33 сургуулийн сургалтын менежер, 180 гаруй бага ангийн багш, 3 захирал оролцлоо. Тус зөвлөгөөнд бүсийн зөвлөгөөнөөс гарсан “Сайжруулсан хичээл” 6, сургалтыг дэмжих 2 үйл ажиллагааны цагийн арга зүйг түгээж, хэлэлцүүлэгтэй хичээл заагдан, Шаамар, Ерөө, Баянгол сум, Хөтөл, Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагааны үзүүлэх тоглолт хийн, харилцан туршлага солилцсон үр дүнтэй ажил боллоо.

## **2. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:**

“Дэлхийн эрүүл мэндийг дэмжих өдөр”-ийг тохиолдуулан, “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас Сүхбаатар сумын ерөнхий боловсролын I, II, IV-р сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор “Эрүүл мэнд-Эрхэм баян”сэдэвт сургалтыг 2015 оны 04 сарын 15-17 өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтаар өсвөр үеийн сурагчдад “Өсвөр үеийн охидын жирэмслэлт, үр хөндөлт, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл, осол гэмтлээс сэргийлье, зөв зохистой хооллолт” зэрэг сэдвүүдээр сургалт хийлээ.

Олон улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан Аймгийн Биеийн тамир спортын газар, Эрүүл мэндийн газар хамтран 2015 оны 04 сарын 20 өдөр “Идэвхитэй хөдөлгөөн эрүүл амьдралын үндэс”нийтийн биеийн тамир, арга хэмжээг зохион байгуулж, Партизаны талбайд иргэдийн биеийн жингийн индекс, цусны бүлэг, сахар холестринийг тодорхойлж, артерийн даралтыг үзэн, эмчийн зөвлөгөөг өгч ажиллалаа. Давхардсан тоогоор 400-д иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж ажилласан нь иргэдийн талархлыг хүлээсэн ажил боллоо.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа Прокорор, Улсын бүртгэлийн хэлтэс, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хаан банкны ажилчдад Заавал хэвшүүлэх 21 дадлыг хэвшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар хөдөлгөөн эрүүл мэнд, зөв зохистой хооллолт, артерийн даралт ихсэх өвчин, биеийн жингийн индекс тодорхойлох сэдвийн хичээл заан, хөгжимт дасгал, ажлын байран дээрх дасгал зэргийг заалаа.

Аймгийн эрүүл мэндийн газрааг “*Í eîí Oëñûí ñóâèèã: í àðûí ° äëð*”-*èéã* тохиолдуулан “*Бèä ì àí èàééí à*” сэдэвт сургалтыг аймгийн нэгдсэн эмнэлэг, сум *òî ñã í û ýðççë ì ýí äèéí ò° äèéí òóñèàð àæèèðàí í àðûí ñóðããèèòû ä çî òèí í äàéãýуллаа. Онол дадлага хосолсон вакумжуулсан тус сургалтанд 4 ээлжээр 140 òóñèàð àæèèðàí òàí òàããàðààñ* нийт 72 *òóñèàð àæèèðàí* ахамруулаад байна.

Хүүхдийн спортын 5-р наадмын 2 дахь шатны Сагсан бөмбөгийн идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 10 сум 3 тосгоны 16 охид, 21 хөвгүүдийн багийн нийт 290 тамирчид оролцож, хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Охидын 1 байранд Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль, 2 байр Мандал сумын 1-р сургууль, 3-р байранд Хөтөл ерөнхий боловсролын сургууль, Хөвгүүдийн 1 байр Баянгол сумын ерөнхий боловсролын

сургууль, 2 байр Мандал 1-р сургууль, 3 байр Сүхбаатар сумын 1-р сургууль тус тус шалгарлаа.

2015 оны 04 сарын 20-23-ны өдрүүдэд Биеийн тамир спортын хөгжлийн төв, аймгийн Биеийн тамир спортын газар хамтран Төвийн бүсийн аймгуудын Биеийн тамир, спортын газрын дарга, мэргэжилтэн, арга зүйч, дасгалжуулагч, биеийн тамирын багш, Эрүүл мэндийн газрын биеийн тамир чийрэгжүүлэлтийн мэргэжилтэн нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 80 гаруй хүн оролцлоо.

### **3. Нийгмийн даатгалынталаар:**

4 сарын байдлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангуудад 8291.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 7942.5 сая төгрөг хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 95.7 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 14181 тэтгэвэр авагчдад 11.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 1525 даатгуулагчдад 570.4 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын, тэтгэмж олголоо.

Үйлдвэрлэлийн осол, мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 285 даатгуулагчид 269.0 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувилалын зардалд олгож, ажилгүйдлийн даатгалын сангаас 199 даатгуулагчдад 191.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

### **4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2481 иргэнд 1.263 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1189 иргэнд 341.2 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 2134 иргэнд 123.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 128 иргэнд 42.6 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээг үзүүллээ.

Эхийн алдар одонтой 7708 эхэд 1.054.1 сая төгрөгийн тусламжийг олгон, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2234 эхэд 384.9 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 59 иргэнд 31.7 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд 796 иргэнд 137.2 сая төгрөгийг тус тус олгоод байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг ард иргэдэд цаг хугацаанд нь олгосон.

### **5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс “Мэргэжил бүхэн сайхан” сэдэвт сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 07-17-ны өдрүүдэд Хүдэр, Жавхлант, Хушаат, Орхонтуул, Баруунбүрэн, Сант сум, Бугант тосгоны ерөнхий боловсролын 9-12 дугаар ангийн 8 бүлгийн 451 сурагчийг хамруулан зохион байгууллаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар сумдаас нийт 42 иргэний 66000.0 мянган төгрөгийн төслийг хүлээн авч, төсөл сонгон шалгаруулах комиссоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

“Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт нийт 70 иргэний 112500.0 мянган төгрөгийн төслийг хүлээн авч, төсөл сонгон шалгаруулах комиссоор хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Газрын асуудлаа шийдвэрлэсэн 10 сум 3 тосгоны бүлгээр хүнсний ногоо тариалах иргэдийн төслийг хүлээн авч, гэрээ байгуулан санхүүжилтийг олголоо.

### **6. Хүүхэд залуучуудын талаар:**

Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги, “Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх аяны хүрээнд Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй 2, 7 дугаар цэцэрлэгүүдэд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсээс хүүхдийн хүмүүжиж байгаа орчинтой танилцан, нөхцөл байдалд үнэлгээ хийж,

орчны ариун цэвэр, эрүүл аюулгүй байдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажил байдалтай танилцлаа.

Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлөөс цэцэрлэгийн хүүхдийн тоглож наадах нөхцөлийг бүрдүүлж, тоглоомоор хангах зорилгоор “Сэтгэлийн дэм 3” сарын аяныг 4 сарын 15-аас 5 сарын 15-ныг хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

“Уран жиргээ-2015” аймгийн аварга шалгаруулах уралдааныг Дулаанхаан тосгонд зохион байгуулж, нийт 63 хүүхэд оролцон 4 насны ангиллаар 12 хүүхэд улсын уралдаанд оролцох эрхтэй боллоо.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 43 мал эмнэлэг үржлийн нэгж, сумдын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гурвалсан гэрээг байгуулж, 2015 оны бодлого зорилтоо тодорхойллоо.

Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран “Байцаа үрслэг бойжуулалт, тариалалт, хураалтын технологи” сэдэвт 3 хоногийн сургалтыг аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар зэрэг сумдын 70 ногоочдыг оролцуулж, сертификат олголоо

Аймгийн хэмжээнд мал төллөлт хэвийн явагдаж байна. Нийт 678227 толгой эх мал төллөхөөс 429448 мал төллөж, үүнээс ингэ54, гүү3840, Үхэр33387, эм хонь229009, эм ямаа163158 төллөн, төллөлт 63.3 хувьтай, төл бойжилт 98.8 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол 2096 толгой мал хорогдсон нь урьд оны мөн үеээс 1466 толгой малаар өссөн үзүүлэлттэй байна.

Үлийн цагаан оготной байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймагт бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготно устгалд Баруунбүрэн, Орхон, Сайхан, Сант, Баянгол сумды 30 мянган га-д устгал хийхээр төлөвлөн, өвс, ногоо ургахаас өмнө яаралтай малчдын хоршоо, малчин өрхөөр хийлгэж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Манай аймгийн тэжээлийн нөөцөнд 90 тонн хивэг, 5000 боодол өнжсөн өвс байгаагаас малчин мал бүхий иргэдэд хөнгөлттэй үнээр зарж энэ сарын байдлаар 19.7 тонн хивэг, 375 боодол буюу 7.5 тонн өвс борлуулаад байна.

### **Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

#### **1. Газрын харилцааны талаар:**

Газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас Баянгол, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сайхан, Сант, Хушаат сумдад ажиллаж 1403 иргэнд 845.741 сая төгрөгийн үнэ бүхий 105.69 га газрыг өмчлүүллээ.

Сүхбаатар сумын иргэдээс газар өмчилж авсан нийт 25, Алтанбулаг сумын Засаг даргын захирамжаар газар өмчилж авсан нийт 18 иргэнд газар өмчлөлийн материалыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ.

Хаан банкны 54 ажилтан албан хаагчдын газар өмчлөх тухай хүсэлтийг хүлээн авч тухайн хүсэлтийг Алтанбулаг сумын 3-р баг 2 элсний баруун талд олгохоор төлөвлөлөө.

Газрын харилцааны албан хэрэгцээнд ашиглагддаг программ хангамж шинэчлэгдэж “Land Manager” программыг нэвтрүүлэх болсонтой холбоотой 16 суманд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын бүх мэдээллийг мэдээллийн баазад оруулж дуусгах зорилгоор энэ сард 365нэгж талбарын хувийн хэргийг мөн “Газар өмчлөлийг эрчимжүүлэх” ажлын хүрээнд газар өмчлөл явагдсан Сайхан



сумын 262 иргэн, Орхон сумын 170 иргэний нэгж талбарын хувийн хэргийн мэдээллийг мэдээллийн баазад шивж орууллаа.

## **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг Сайхан суманд ажиллаж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилуудадхяналт, шалгалт хийлээ.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас Мандал суманд Төрийн орон сууцны корпорацийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 126 айлын орон сууцны барилгын гадна шугам сүлжээний ажилтай танилцлаа. Гадна цахилгааны 2 эх үүсвэрийн нэг эх үүсвэр нь кабелиар 380 метр, нөгөө эх үүсвэр нь агаараар 1.6 км шугам татахаар байгааг нэгтгэн нэг эх үүсвэртэй болгож кабелиар татах санал гаргаж хөрөнгө оруулалтын хэмжээг багасгах саналыг “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК -д албан тоот хүргүүлж, дулааны эх үүсвэр болох төмөр замын зууханд очиж үзэхэд Төрийн орон сууцны корпорациас тус барилгыг найдвартай дулаанаар хангаж чадахгүй гэсэн дүгнэлт гаргасан.

“Төгс Үндэс” ХХК-ийн 30\*2 айлын орон сууцны барилгын скиз зураг, Сант сумын 12 айлын орон сууцны барилгын гадна дотор ариутгах татуургын зураг төсвийг хянаж баталгаажууллаа.

## **3. Байгаль орчны талаар:**

Тайлант сарын 2, 4, 10, 14-нд зарим сумдын нутгаар 0,0-3,0 мм, 15, 17-нд ихэнх сумдын нутгаар 0,0-2,0 мм хур тунадас орлоо. Бусад хугацаанд хур тунадас ороогүй.

I-р арав хоногийн дунд үеээр бага зэрэг хүйтэрч шөнөдөө 10-15 градус хүйтэн, бусад хугацаанд шөнөдөө 2-7 градус хүйтэн байв. Өдрийн температурын хувьд I-р арав хоногийн дунд үеээр сэрүүсч 0-5 градус, 2-р арав хоногийн эхэн үеээр дулаарч 21-26 градус бусад хугацаанд 8-13 градус дулаан байлаа.

Салхи ихэнх хугацаанд баруун болон баруун хойноос 5-10 м/сек байлаа. 15, 18-нд салхи ширүүсч 9-14 м/сек, зарим үед түр зуур ширүүсч 15-20 м/сек хүрч байв.

4-р сарын II арав хоногийн байдлаар ихэнх сумдын нутгаар бэлчээрийн төлөөлөх ургамал агь, хялгана, ерхөг, хиагны цухуйлт эхэлсэн, ургамлын өндөр 0-3 см, ургалтын балл сайн гэсэн үнэлгээтэй байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлд ихэнх сумдын нутгаар малд нэмэгдэл тэжээл өгөх, бог, бод мал төллүүлэх, хөөвөр хялгас авах ажил үргэлжилж байна. Цаг агаарын байдал энэ арав хоногт ихэнх сумдын нутгаар тохиромжтой байлаа.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0,012 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,017 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн дундаж агууламж 0,003 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,004 мг/м<sup>3</sup>, агаар дахь тоосжилтын дундаж агууламж 0,020 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,025 мг/м<sup>3</sup> байна. Мандал суманд Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0,010 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,013 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн дундаж агууламж 0,002 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,004 мг/м<sup>3</sup> байна.

## **Долоо.Сум орон нутгийн талаар:**

### **1.Алтанбулаг сум:**

Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан цэцэрлэгийн хүүхдүүдийг газар хөдлөлтөөс авран аюулгүй газарт хүргэх сургалт дадлагад аврах бүлгийн 16 аврагч оролцож ахлах бүлгийн 33, бэлтгэл бүлгийн 33, нийт 66 хүүхэд хамрагдлаа.

2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Дамбо цэцэрлэгийн хамт олон, эцэг эхчүүд хамтран 4-р сарын 1 буюу инээдмийн баярыг тохиолдуулан “Эдийн засгийн хямралыг инээдээр эмчилье” сэдэвт хошин шогийн тэмцээнийг Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагуудын дунд зохион байгууллаа.

Шүүхээс баривчлах арга хэмжээ авагдсан тус сумын иргэдэд 2015 оны 04-р сарын 15-нд сумын цагдаагийн хэсэг, Засаг даргын тамгын газар хамтран архины хор хөнөөл, хор уршиг өөрсдийн эрүүл мэнд амьдрал, нийгэмд сөргөөр нөлөөлж буй талаар яриа таниулгийг хийж, иргэдийнхээ санаа бодлыг сонсож, харилцан санал солилцлоо.

Их эрдэмтэн, зохиолч, академич Бямбын Ринченгийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан Б.Ринченгийн нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн хамт олноос 2015 оны 04 сарын 17-нд төр, төсвийн байгууллагуудынхаа дунд Б.Ринченг хэр сайн мэдэх вэ? Аст танин мэдэхүйн хөгжөөнт арга хэмжээг зохион байгуулаа.

## **2.Баруунбүрэн сум:**

Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан гал түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах зорилгоор тус сумын Засаг даргын 2015оны А/23 тоот захирамжийг нийт 195 иргэнд танилцуулан гарын үсгийн баталгаажуулалт хийлээ.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Иргэдээ хүлээж биш хүрч үйлчилье” уриатайгаар 2014 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулан, энэ онд зохион байгуулагдах төсөл хөтөлбөр, ажил үйлчилгээний талаар мэдээлэл хийлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга нар хөдөөгийн малчдын хаваржилтын байдалтай танилцаж, 205 малчин өрхөөр орж хүн, малын эмчилгээ үзүүлэн, малчдад цаг үеийн мэдээллийг өгч, хамтран ажиллах дөрвөлсөн гэрээг байгууллаа.

Сумын Засаг даргын мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах 2015 оны А/66 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, халдварт өвчнөөс урьдчилан шөвөг ярын вакцинд 6500ишиг, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 400 үхэр 300 нохой, туулгалтанд 115 нохой, нийт 7315 толгой мал амьтдыг хамруулаад байна.

## **3.Ерөө сум:**

Аймгийн Засаг даргын 2015 оны А/82 тоот захирамжаар 2015 оныг “Иргэн таны төлөө” жил болгон зарласантай холбогдуулж, Ерөө сумын Засаг даргын 2015 оны А/72 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан, жилийн ажлын нээлтийг 2015 оны 04 сарын 20-ны зохион байгуулж нийт 150 гаруй иргэд хамрагдлаа.

Нийт 17 сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2015 оны 04 сарын 17-нд төр, төсвийн байгууллагуудынхаа дунд Б.Ринченг хэр сайн мэдэх вэ? Аст танин мэдэхүйн хөгжөөнт арга хэмжээг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас иргэдийн архигүй, эрүүл тайван орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 13 аж ахуйн нэгжүүдээс 10 аж ахуйн нэгжийг хамруулан хяналт шалгалтыг зохион байгууллаа.

## **4.Жавхлант сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуулийн хамт олноос 2015 оны 03 сарын 27-ний өдөр Дамбо цэцэрлэгийн хамт олон, эцэг эхчүүд хамтран 4-р сарын 1 буюу инээдмийн баярыг тохиолдуулан “Эдийн засгийн хямралыг инээдээр эмчилье” сэдэвт хошин шогийн тэмцээнийг Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагуудын дунд зохион байгууллаа.

өгөх, 0° дөеи аааа бааа-аын үйл ажиллагааны талаар өдөр ааас нүүдэе баи аи ааеи нөөааеаа аааа ажлуудыг хийлээ.

Нои үи 0° аа Аои ааа, л ии нөи е ааааааи Аааеи идэуаеи Неедөеи Хурлыг зохион байгуулж, бааеи Чааааааааа и аа 2014 ии ү оаеааи аа бааааа, 2014 ии ү иди и ооаеи 0° ааеи нәи аеи 0° 0° 0° 0° өеаааи аааи оүдүааеөдөеи бааааа иргэдэд и үүүүеө 0° аа, 2016 ии ү иди и ооаеи 0° ааеи нәи аеи хөрөнгөөр хийгдэх ажил арга хэмжээний талаар өдөр үүүү нәи аа аааа.

“Иргэн таны төлөө” уриан дор “Бидний оролцоо” аяныг сумын хэмжээнд үи өеи и аааааааа 0° ааеи аүдөө үүөдүе өдөр ааеи аои а өөааи аааааа өнөөааын талаар оүеүөө үүүүааааа и өө 36 өдөр баи бааааа.

### **5.Зүүнбүрэн сум:**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 339, 340 дүгээр тогтоолын дагуу сумын Засаг даргын А/40 тоот захирамжаар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах талаар Засаг даргын Тамгын газраас дуут дохио ажиллуулан төр төсвийн байгууллага аж ахуйн нэгжүүд байгууллага дээрээ газар хөдлөлтийн үед хэрхэн өөрийгөө болон бусдыг аврах талаар үзүүлэх сургалт зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/73 тоот захирамжийн дагуу иргэдийн газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх аяны хүрээнд газар өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй иргэдийн газрыг бүртгэн гэрчилгээжүүлэх ажлыг эхлүүлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Оюуны хөгжил төрийн бус байгууллагатай хамтран “Ажлын байрны харилцаа ёсзүй” сэдвээр сургалт зохион байгуулж нийт сумын төр төсвийн байгууллагуудын 36 албан хаагчийг хамрууллаа.

Сум хөгжүүлэх сангаас 2013 онд зээл авсан 50 иргэнээс зээлийн хугацаа дууссан 4 иргэнд зээлийг төлж барагдуулах мэдэгдэл өгч, заасан хугацаандаа зээлээ төлөөгүй 3 иргэнтэй холбогдох материалыг сум дундын 9-р шүүхэд шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

### **6.Орхонтуул сум:**

Сумын “Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх сумын хөтөлбөр”, “Амьдралын төгөл хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын Тамгын газраас “Амьдралын төгөл” аянг 2015 оны 03-р сарын 26-аас 05-р сарын 16-ныг хүртэл зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд иргэдэд экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, Баянцогт 2-р багт 2,4 га, Рашаант тосгонд 1,4 га талбайд мод тарьж иргэдийн амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэхүү ажлыг иргэд, малчдад сурталчлах зорилгоор “Мэдээллийг өрх бүрт” арга хэмжээгээр нийт 247 өрхөд хүрч ажиллаад байна.

Нийт сүргийн бүтцэд эзлэх эрчимжсэн малын тоо жил бүр тогтвортой өсөж мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд үнэтэй хувь нэмэр оруулж буй малчин иргэдэд хүндэтгэл үзүүлэх зорилгоор “Буман төлийн баяр” арга хэмжээг сумын Засаг даргын А/46 тоот захирамжаар 2015 оны 05-р сарын 20,21-ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Уг арга хэмжээний хүрээнд 3 насны хурдан морины уралдаан, үндэсний бөх, сур, шагайн тэмцээнүүд, баярын хурал, хүндэтгэлийн концерт зэрэг арга хэмжээнүүдийг улс, аймаг, сумын аварга малчидтай хамтран зохион байгуулах юм.

2015 оны 04-р сарын 11, 18-ны өдрүүдэд “Үндэсний өв соёлоо тээгч, түгээгч”-улсын уралдааныг тус сумын ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгууллаа.

Сумын Соёлын төвөөс “Хөдөлгөөнт номын сан”, “Цэргийн жавхаа” АСТ, Нийтийн цэнгээнт бүжиг, Рашаант тосгоны ахмадуудын уран бүтээлийн тоглолт

зэрэг 4 удаагийн арга хэмжээгээр давхардсан тоогоор 150 гаруй хүнд хүрч үйлчиллээ.

#### **7.Сант сум:**

Тайлант сарын байдлаар Сант сумын хэмжээнд 23947 толгой мал төллөж, мал төллөлт 83,5 хувьтай явагдаж байна. Үүнээс адуу 264, үхэр 703, хонь 13700, ямаа 9280 төллөж, төлийн хорогдолгүй төл бойжилт 100 хувьтай байна.

Сумын Засаг даргын 2015 оны А/46 тоот захирамжаар тариалангийн талбайн хөнөөлт шавьж, мэрэгч амьтантай тэмцэх ажлыг тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 14 хоногт багтаан зохион байгуулж, малчид болон мал бүхий иргэдийн малыг өгөөш цацсан талбайд оруулахгүй байлгах хорио цээр тогтоож, хяналт тавьж ажиллаж байна.

“Хог хаягдлын дэг журам тогтоох тухай” сумын Засаг даргын 2015 оны А/44 тоот захирамж гарч сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдийн нийтийн эдэлбэр газраас хуваарьт заасан газар нутаглаж буй орчмын газрын цэвэрлэгээг долоо хоног бүрийн баасан гаригт хийж байхаар тогтоолоо.

#### **8.Сайхан сум:**

“Рио-2016” зуны Олимпийн наадмыг угтаж Монголын үндэсний олимпын хорооны “Аваргыг аймагтаа бэлтгэе” хөтөлбөрийн хүрээнд орон нутагт олимпийн хөдөлгөөнийг эрчимжүүлэх, хүүхэд, залуучуудын Олимпийн боловсролыг нэмэгдүүлэх, алдар цуутай тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор “Рио-2016” цомын аяныг Сайхан сумын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж нээлтийн үйл ажиллагааг 2015 оны 04 сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд 27 аж ахуйн нэгж айгууллагын 600 гаруй ажилтан, албан хаагч, хүүхэд залуучууд хүрэлцэн ирлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг сонсох зорилгоор “Бидний оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгийг Номгон тосгоны Захирагчийн алба, Эрүүл мэндийн төв, газрын албатай хамтран зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн хамгааллын тухай хуулийн танилцуулга, зөвлөгөө өгч, тэдэнд тулгамдаж байгаа асуудлын талаар харилцан санал солилцлоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Гэмт хэрэг зөрчлийн эсрэг хамтдаа” аяныг зохион байгуулж, Орхон бүсийн хэмжээнд төр төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын 32 албан хаагч, иргэдийн хамруулсан хэлэлцүүлэг хийлээ.

2015 оны 04 сарын 9,10-ны өдрүүдэд “Сайн сайхан зан чанарыг хэрхэн төлөвшүүлэх вэ?” сэдэвт сургалтыг “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль, БХАН-тэй хамтран зохион байгуулж, сургалтанд Орхон бүсийн 95 багш оролцлоо.

#### **9.Сүхбаатар сум:**

“Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг угтан Сүхбаатар сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” сарын аяныг зохион байгуулж байна.

Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цахим тоглоомын газрын өнөөгийн” байдал” сэдэвт хэлэлцүүлгийг аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Цагаадгийн газар, сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж, хэлэлцүүлэгт Сүхбаатар суманд Цахим тоглоомын газрын үйл ажиллагаа эрхэлдэг



### **13.Шаамар сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас төмс, хүнсний ногоо тариалдаг 30 гаруй өрхийн үйл ажиллагаатай танилцаж, 50 гаруй иргэдтэй уулзалт зохион байгуулан үрслэг тариалалт, тариалалтын бэлтгэл ажлын талаарсанал солилцлоо. Сумын иргэд хүнсний ногооны талбайгаа урьдчилсан байдлаар 40 гаруй өрх 30 гаруй га талбайд бууцаар бордоод байна.

Сумын ерөнхий боловсролын сургуулиас 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Хүчирхийлэлгүй хүүхдийн ертөнц” дэвжээ, бага ангийн сурагчдын дунд “Гэр бүлийн аз жаргал” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгууллаа.

Зорилтот бүлгийн өрхийн гишүүн, иргэнийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулахаар 3 өрхийг сонгон авч, сонгосон өрхүүдтэй уулзаж санал бодлыг хүлээн авлаа.

### **14.Түшиг сум:**

2015 оны 04 сарын 04-06-ны өдрүүдэд аймгийн ахмадын гар бөмбөгийн тэмцээний аварга шалгаруулах тэмцээнийг спортын мастер П.Гансүхийн нэрэмжит болгон аймгийн Биеийн тамир спортын газар, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Шинэ бадрах ХХК хамтран зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг хамтран 2015 оны 04 сарын 21-ний өдөр “Эцэг эхийн өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр сурагчдын эцэг эхийн төлөөлөл иргэд, болон сургууль, цэцэрлэгийн ажилчид албан хаагчдад хандан мэдээлэл хийж, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргалаа. Тус арга хэмжээний нийт 100 гаруй эцэг эх хамрагдлаа.

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас Эрүүл мэндийн төв, мал эмнэлэг, багийн Засаг дарга нартай хамтран сумын малчдын хаваржилтын байдалтай танилцан, мал төллөлт, бойжил, хорогдлын мэдээг авч, 44 өрхийн 176 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР